



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэхь хэсэг 4.2.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 4 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2022 оны 9 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын
08-ны өдрийн /10/ тоот тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр
хязгаарлах арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны
компаниуд**

1. "Евразиа капитал холдинг ҮЦК" ХК
2. "Масдак ҮЦК" ХХК
3. "Монгол секьюритиез ҮЦК" ХК
4. "Централ секьюритийз ҮЦК" ХХК

---oOo---